

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.340.99

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Хамгаалах хашлага, ерөнхий шаардлага	MNS XXXX:XXXX
Occupational health and safety, Protective barriers-General requirements	MNS 12.04.007 : 1981-ын оронд

Стандартчилал, Хэмжил зүйн газрын даргын ... оны ... дугаар сарын ...-ны өдрийн дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь ... оны ... дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Энэ стандарт нь барилга угсралтын ажил, үйлдвэрлэлийн болон бусад төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын аюултай бүс, өндөрт байрлах талбай, нүх, шуудуу, тоног төхөөрөмж, түр болон байнгын тавцан, шат, замын ирмэг зэрэг хүн унах эрсдэл бүхий орчныг хамгаалах зорилгоор хамгаалах хашлага төлөвлөх, угсрах, ашиглахад тавигдах ерөнхий шаардлагыг тогтооход хэрэглэнэ.

Энэхүү стандартад дараах онцгой зориулалтын хашлага хамаарахгүй. Үүнд:

- Цэргийн болон батлан хамгаалах зориулалттай объектууд
- Экологийн хувьд аюултай үйлдвэр, үйл ажиллагаа
- Цөмийн болон цацрагийн аюултай объектууд
- Стратегийн нөөц болон амин чухал дэд бүтцийн объектууд
- Дулаан ба усан цахилгаан станцууд, хамгаалалт шаарддаг эрчим хүчний объектууд

2 Нэр томьёо, тодорхойлолт

2.1

Хамгаалалтын хашлага

Барилга байгууламжийг барих засварлах үед өндрөөс хүн унагахгүй хамгаалах зориулалттай хамгаалалт

2.2

Барилга байгууламжийн засвар

Барилгын үндсэн зориулалт болон техникийн үзүүлэлтийг өөрчлөхгүйгээр түүний физик элэгдэл, эдэлгээний хоцрогдлыг арилгах зорилгоор гүйцэтгэх ажил буюу техник–зохион байгуулалтын цогц арга хэмжээг

2.3**Барилга угсралтын ажил**

Бүх төрлийн барилга байгууламж барих, өргөтгөх, шинэчлэлт ба засварын ажил гүйцэтгэх болон тоног төхөөрөмж суурилуулах үйл ажиллагааг

2.4**Хашлаганы материал**

Хамгаалалтын зориулалтаар ашиглагдах мод, металл, төмөр тор, хуванцар гэх мэт аюулгүй байдал хангах шаардлагатай материал

2.5**Холбох элемент**

Хашлаганы эд ангиудыг бэхлэх зориулалт бүхий боолт, гагнаас, хавчаар зэрэг эдлэлүүд

2.6**Ажлын бүсийн хязгаарлалт**

Барилгын талбайн аюултай бүсийг хязгаарлаж, зөвшөөрөлгүй нэвтрэлтийг хориглоход зориулсан хашлага

2.7**Аюултай бүс**

Хүнд уналт, тоног төхөөрөмжийн осол, ачаалал даах чадвар хэтрэх эрсдэлтэй хэсгийг тодорхойлно

2.8**Хэт ачааллын коэффициент**

Аюулгүй байдлыг хангахын тулд хашлаганы тооцоололд ашиглагдах ачааллын итгэлцүүр

2.9**Ачааллаас үүсэх хотойлт**

Хашлаганд үйлчлэх статик болон динамик ачааллын улмаас үүсэх гажилт, хазайлт, хэлбэлзэл. Тооцооны зөвшөөрөгдөх хэмжээг стандартаар тогтооно

2.10**Бэхэлгээ**

Хашлага болон түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг тогтвортой байлгах, хөдөлгөөнөөс хамгаалах, бүтэц дээр найдвартай холбож тогтоох зориулалттай механик эсвэл бүтцийн холболтын систем

3. Ерөнхий зүйл**3.1 Зорилго**

Энэ стандартын зорилго нь барилга угсралтын ажил, үйлдвэрлэлийн болон бусад төрлийн үйл ажиллагааны явцад хүмүүс унах, гэмтэх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг зөрчихөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалах хашлаганы хийц, хэмжээ, бүтэц, зохион байгуулалт болон угсралт, ашиглалтад тавигдах ерөнхий шаардлагыг тогтооход оршино.

3.2 Хамгаалах хашлагыг энэхүү стандарт болон зохих журмын дагуу батлагдсан техникийн баримт бичгийг баримтлан үйлдвэрлэж хэрэглэнэ.

3.3 Байнгын хамгаалах хашлагагүй барилгын хучилт, тээвэрт гаргасан нүх,

тэдгээрийн ирмэг зах уруу хүн унахаас болгоомжлоход энэ хамгаалах хашлага зориулагдана.

3.4 Хамгаалах хашлага нь ашиглалтын үед цаг агаарын халуун, хүйтэн нөхцөл, чийглэг, нарны цацралт зэрэг үйлчлэлээс өөрийн хамгаалах шинж чанараа алдахгүй байвал зохино.

3.5 Хамгаалах хашлаганд хэрэглэх материал нь үйлдвэрлэлийн ямар нэгэн гэмтэлгүй байна.

3.6 Барилга барих, засварлах ажлын технологитой уялдуулан уг ажлыг хийж гүйцэтгэх төсөлд тусгасан хамгаалах хашлагыг зориулалтын дагуу хэрэглэнэ.

4. Техникийн шаардлага

4.1. Хамгаалах хашлагыг бэлтгэхдээ хөнгөн чанарын, угсарч задлахад тохиромжтой материалыг хэрэглэнэ.

4.2. Барилга байгууламжийн тогтвортой хөдөлгөөнгүй хийцүүдэд хамгаалах хашлагыг бэхлэх зангилгаануудын хоорондын зай нь техникийн баримт бичгээр тодорхойлогдох бөгөөд 6 метрээс ихгүй байх ёстой.

4.3. Хамгаалах хашлаганы үндсэн бүх элементүүдийн бат бэхийн болон хашлагыг нийтэд нь хэвтээ ба босоо чиглэлд жигд тархсан 40 кг. х/м норматив ачааг хашлаганы бариул дээр үйлчлүүлж тогтворт чанарыг нь тооцсон байна. Хоёроос илүүгүй хүн ажиллах газар хашлаганы бариулын уртын дагуугийн аль нэг хэсэгт хэвтээ буюу босоо чиглэлд байрласан 40 кг.х-тэй тэнцүү төвлөрсөн норматив ачаагаар үйлчлүүлж туршихыг зөвшөөрнө.

- Хэт ачааллын коэффициентийг 1,2-оор авах ёстой.

- Ачааллаас үүсэх хотойлтын хамгийн их хэмжээ нь 0.1 м-ээс хэтрэхгүй байна.

4.4. Үндсэн хашлаганы улнаас бариулын (хэвтээ элемент) дээд тал хүртэлх хамгаалах хашлаганы өндөр 1.1 м-ээс багагүй байна.

4.5. Босоо хавтгайд хэвтээ чиглэлээр байрласан элементүүдийн хоорондох зай 0.45 м-ээс их байж болохгүй

4.6. Барилгын хучилт, дээвэр дээрээс жижиг ширхгийн материал болон хаягдлууд унахаас болгоомжилж хамгаалах хашлаганы хажуугийн элементүүдийг хашлаганы улнаас 0.15 м-ээс багагүй өндөрт байрлуулна.

4.7. Хамгаалах хашлаганы хийцийн элементүүд нь 20 кг-аас ихгүй жинтэй байна.

4.8. Хашлагыг бэхэлж тогтоох барилга байгууламжийн бүтээц нь уг хашлаганд тооцогдсон бат бөх, тогтвортой чанарыг хангасан байна.

4.9. Хамгаалах хашлаганы бэхэлгээ нь өөрөө салж задрахаар байж болохгүй

4.10. Хэрэглэж байгаа материал, гагнуурын оёдол, боолт, хадаас болон тавт холбооснуудын чанар нь тогтоогдсон журмын дагуу батлагдсан норматив техникийн баримт бичгийн шаардлагыг хангасан байна.

4.11. Хамгаалах хашлага хайсыг хурц тод өнгөөр будна.

5. Хүлээж авах журам

- 5.1. Бэлтгэн нийлүүлэгч нь хамгаалах хашлагыг энэ стандарт, ажлын зургийн дагуу хүлээж авах ба хүлээлгэн өгөх, туршилт шалгалтыг явуулна.
- 5.2. Хашлага бүрийг нэг бүрчлэн хүлээж авах бөгөөд шалгалтад дараах дэс дарааллыг баримтална. Үүнд:
 1. Элементүүдийн бүрэн бүтэн байдал;
 2. Хэрэглэсэн материал, түүний хэмжээ ажлын зурагтай тохирч байгаа эсэх;
 3. Хашлаганы будалт шаардлагад нийцэж буй эсэх;
 4. Гагнаас, боолт, хадаас, тавт холбооснууд, канатын (татлага), чанар техникийн баримт бичгийн зохих шаардлагад тохирч буй эсэхийг тус тус хамруулж шалгана.
- 5.3. Хүлээн авч нийлүүлэх туршилтыг хийхдээ тухайн хэсгийн 5 %-ийг туршилтад авах бөгөөд хашлаганы загварын тоо 5-аас цөөнгүй байна.
- 5.4. Хэсгийн хэмжээг нэг хэлбэрийн буюу нэг төрлийн ба нэг хаягаар хэрэглэгчид нийлүүлсэн зэргээс хамааруулан тогтооно.
- 5.5. Хүлээн авч нийлүүлэх үед туршилтыг хийхдээ хашлаганы бат бөх, тогтвортой байдлыг заавал шалгана.
- 5.6. Хэрвээ хүлээн авч нийлүүлэх туршилтын үед аль нэгэн хашлага шаардлага хангахгүй байвал туршилтад авах загварын тоог хоёр дахин нэмэгдүүлж дахин туршина.
- 5.7. Энэхүү хоёр дахь туршилтаар шаардлага хангахгүй байвал хашлагыг нэг бүрчлэн шалгаж хүлээж авна.
- 5.8. Туршилтын дараа хамгаалах хашлаганы хэв дүрс алдагдаагүй, бэхлэлт сулраагүй, тогтвортой байдал хэвээр байвал туршилтыг тэсвэрлэсэнд тооцно.
- 5.9. Энэхүү стандартын 4.3-р зүйлд заасан шалгалт туршилт хийхийг үйлдвэрлэгч шаардах эрх эдэлнэ.

6 Шалгах арга

- 6.1 Хашлагыг хүлээн авахдаа стандарт, техникийн баримт бичигт тохирч байгаа эсэхийг шалгана. Тухайлбал: Хамгаалах хашлаганы элементүүдийн будаг бүрэн эсэх, хугаралт, цавтай эсэх, гагнуурын оёдлын чанарт үзлэг хийж хэмжинэ.
- 6.2 Материалын чанарыг лабораторийн шинжилгээний дүнгээр тодорхойлох буюу чанарын баталгаагаар нь тогтооно.
- 6.3 Хашлаганы хэмжээг зурагт заасны дагуу тусгай харьцуулах загвараар буюу хэмжих багажаар нарийн тодорхойлно.
- 6.4 Хашлаганы бат бөх, тогтвортой байдлыг ажлын байдалд нь энэхүү стандартын 3.3-р зүйлд заасан тооцооны ачаагаар туршиж шалгана.

7 Марклалт, савлалт, тээвэрлэлт ба хадгалалт

- 7.1 Үйлдвэр, аж ахуйн газар-бэлтгэгч бүрд явуулж байгаа хэсэгт дараах агуулга бүхий марклалтыг хамгаалах элемент дээр үйлдэнэ. Үүнд:

7.1.1 Барааны тэмдэг эсвэл үйлдвэрлэгч байгууллага

- бэлтгэгчийн товч хаяг;
- хамгаалах хашлага түүний элементүүдийн хэрэглэх хүрээг заасан таних тэмдэг;

7.1.2 Бэлтгэсэн он, сар

7.2 Хамгаалах хашлаганы савлалтын хэлбэр нь бэлтгэгчээс хамаарна. Савлалт нь хамгаалах хашлагыг хадгалах, түүнийг механизмаар ачиж, буулгах бололцоотой байх ёстой.

8 Хэрэглэх заавар

8.1 Хамгаалах хашлагыг байрлуулах, ашиглах салгах үед энэхүү стандартын шаардлагыг биелүүлэх хяналтыг барилга угсралтын байгууллагын инженер техникийн ажилтан (даамал, мастер, хэсгийн механик) гүйцэтгэнэ.

8.2 Хамгаалах хашлагыг байрлуулахдаа энэхүү стандартын 3. 2-р зүйлд заасан шаардлагыг харгалзан гүйцэтгэх ёстой.

8.3 Ашиглалтын үед эвдэрсэн хамгаалах хашлагыг засварт шилжүүлнэ.

8.4 Хамгаалах хашлаганы гэмтэл, түүнийг зассан тухай ажлын журналд тэмдэглэнэ.

8.5 Хамгаалах хашлагыг байрлуулах, авах үед ажлын байрны гэрэлтүүлэг 30 лк-ээс багагүй байх ёстой.

8.6 Хамгаалах хэрэгслийг 10 м/сек буюу түүнээс их хүчтэй салхитай үед ил задгай өндөр газар, тэрчлэн хүчтэй цас, бороо, аянгатай үед байрлуулах буулгахыг хориглоно.

9 Бэлтгэгчийн баталгаа

9.1 Бэлтгэгч үйлдвэр, хамгаалах хашлаганы хэсэг бүрд дараах зүйлийг бичсэн паспортыг дагалдуулах ёстой.

Үүнд:

- Бэлтгэгч, үйлдвэрийн нэр, хаяг;
- стандарт, техникийн нөхцөлийн дугаар;
- хэсгийн дугаар;
- элементийн тоо, жин, нэр;
- хамгаалах хашлагыг хэрэглэх хүрээ (зориулалтаар)
- угсарч, салгахад зайлшгүй мөрдөх заавар;
- баталгаат хугацаа;
- паспорт олгосон хугацаа;

9.2 Хамгаалах хашлаганы ашиглалтын баталгаат хугацаа ашигласан өдрөөс нэгээс доошгүй жил байх ёстой.